

## ДЭЛХИЙН ХҮН АРДЫН ШАШИН ШУТЛЭГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

С.Янжинсүрэн (Доктор, PhD)  
МУИС. ШУС. Философи, шашин судлалын тэнхим

**Тулхүүр үс:** Дэлхийн шашин, үндэстний шашин, овог аймгийн шашин, ардын шашин, шашин шутлэгийн дундаж нас.

**Төвч утга:** Өгүүлэлд өнөөгийн дэлхийн шашин шутлэгүүдийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын тухай авч үзлээ. Ингэхдээ 2010 оны буюу дэлхийн олон орны одоогоор хийгдээд байгаа хамгийн сүүлийн хүн амын болон шашин шутлэгийн тооллогын үр дүнг эш болгов. Судалгаанаас үзвэл ирээдүйд Христосын шашин дэлхийд шүтэн бишрэгчдийн тоогоор тэргүүлдэг байсан зонхилох байр сууриа алдаж, Исламын шашин тэргүүлэхээр байна. Үүнд исламчуудын нөхөн үржихүй чухал нөлөөтэй ба ялангуяа Энэтхэг, Пакистан, Малайзын ислам шутлэгтийн эрс өссөнөөр тэд дэлхийн шашин шутлэгтийн дунд олонх болоход нөлөөлнө гэж үзэж байна. Харин бурханы шашинтны тоо буурахаар байгаа юм.

Ардын шутлэг хэмээх шинэ ойлголт шашин судлалд тогтворжих хандлагатай байна. Ард түмнүүдийн дунд үндэстний хэмжээнд шутэгддэг, гэхдээ өдөр тутмын амьдрал, зан заншилтай холбогдсон шашинуудыг ийнхүү нэрлэж байна. Зарим судлаачид улс үндэстнүүдийн шашин шутлэгийн олон янз байдал хоорондоо уусан нэгдсэн эсвэл холимог байдалтай байгаад дулдуудан тухайн ард түмнийг ардын шашин шутлэгтэй гэж үзэх нь ч байна. Энэ ангилалд үндэстний шашинуудыг оруулж байна.

\* \* \* \* \*

Нийгэм, түүхийн нэгэн зүйл үзэгдэл шашин нь олон хэлбэртэй. Тархсан газар нутгийн хэмжээ, шүтэж байгаа хүн зоны тоо, тэдгээрийн соёл иргэншилд үзүүлсэн нөлөө зэрэгт нь үндэслэн шашныг дэлхийн шашин, улс үндэстний шашин, овог аймгийн шашин гэж ихээс нь бага уруу нь жагсаан ялгаж байна. Бас үүнийг шашныг шүтэн бишрэгч субъектэд нь хамаатуулан ангилсан ангилал гэж үздэг. Ингэж ялгаж байгаа нь цаанаа хүний нийгмийн нийтлэгүүдийн ялгааг илэрхийлдэг.

2010 онд олон улс орон хүн амын нэгдсэн тооллого хийхдээ хүн ардынхаа шашин шутлэгт давхар тооллого хийжээ. Дэлхийн хүн амын шашин шутлэгийн нөхцөл байдал, тархац, чиг хандлагад хийсэн судалгаануудаас үзвэл хамгийн сүүлд хийсэн хүн амын тооллогуудын үр дүнг нэгтгэхэд дэлхийн хүн амын 31.5% (2.2 тэрбум) нь Загалмайн шашинтан, 23.2% (1.6 тэрбум) нь Ислам шашинтан, 7.1% (489 сая) нь Бурханы шашинтан, 15% (1 тэрбум) нь Хинду шашинтан, 5.9% нь (400 сая) ардын шашин шутлэгтэн<sup>1</sup>, 0.2% нь (13.8 сая) Иудайчууд, 0.8% нь (55.2 сая) бусад шашинтан бөгөөд 6.9 тэрбум хүнээс 16.3% нь буюу 1.1 тэрбум нь шашин шутлэгтүй гэсэн дүн<sup>2</sup> гарсан байна. Эндээс үзвэл 2010 оны байдлаар хүн төрөлхтөний 83.7% нь (ойролцоогоор 5.8 тэрбум) шашин шутдэг байна<sup>3</sup>.

<sup>1</sup> Folk religionist

<sup>2</sup> The Global Religious Landscape, A Report on the Size and Distribution of the World's Major Religious Groups as of 2010. Pew Research Center, The Pew Forum in Religion & Public Life, Dec. 2012, p.9.

<sup>3</sup> Эл бүхий судалгааны дэлхийн газар нутгийг Ази номхон далайн бус нутаг; сахарын ойр орчини Африк; Европ, Латин Америк; Хойд Америк; Ойрх дорнод ба хойд Африк хэмээн газар нутгийн ойр дөтөөр нь б бүсэд хувааж тэдэээрийн шашин шутлэгийн байдал хийгээд шашин шутлэг тархсан байдал, түүхэн уламжлал, соёл, үнэлээмж болон хүн амын

Христосын буюу Загалмайтны шашин, Исламын, Буддын буюу Бурханы шашин гурав нь дэлхийн шашин болохыг нийтээрээ мэнднэ. Гэсэн хэдий ч шүтэн бишрэгчдийн тоогоороо дэлхийн шашин болох Буддын шашнаас хол давсан, дэлхий дээрх хэд хэдэн үндэстний шашин, соёлын эх учир Хиндү шашныг, онцлог байдал болон дэлхийн хамгийн том шашнуудын эх сурвалж болсных нь хувьд Иудайн шашныг тусгайлан авч үзэж шүтэн бишрэгчдийнх нь тоо, нөхцөл байдлыг тодорхой гаргах нь элбэг. Тэдний хүн төрөлхтний соёлын амьдралд оруулсан хувь ч нэмэр их. Хиндү шашин бол шашин судлалд одоогоор тогтоогдоод байгаа “анхны шашин” болно. Энэ шашнаас Буддизм, Жайнизм, Сикхизм болон энэтхэгийн бусад олон шашин соёл үүсч хөгжсөн бол Ислам шашнаас дэлхийн 2 шашин, Христос болон Ислам шашнууд үзэл онолын эх сурвалжаа авсан түүхтэй. Хиндү хийгээд Иудайн шашин нь хамгийн өндөр настай шашнууд мөн болно.

Дэлхийн хамгийн олон хүн шүтэн биширч байгаа Христосын шашины байдлыг авч үзвэл тэдний олонх нь Европ тивд оногдож байна. Ази номхон далайн бүс нутагт 7.1% нь буюу 286,5 сая загалмайтны шашинтан ногдож байна.

Ойрхи дорнод болон Хойд африкт хамгийн цөөн буюу 12.7 сая загалмайн шашинтан байна. Европ тивд христос шашинтууд давамгайлж ирсэн түүхтэй. Гэвч 2050 он гэхэд одоогийн хүн ам нь 75%-иас буурч 65% болно гэсэн урьдчилсан тооцоо гарчээ. Түүхийн бүх үед энэ бүс нутагт ислам шашинтан бага байсан бөгөөд 2050 он хурэхэд ч ислам шашин хүн амд эзлэх хувиараа хамгийн бага хэвээрээ буюу европын хүн амын 10% нь л исламын шашинтан байна гэж үзжээ<sup>4</sup>.

#### ДЭЛХИЙН ХРИСТОСЫН ШАШИНТ ХҮН АМЫН ТОО /бүс нутгаар/

	Бүс нутаг	Хүн амын тоо 2010 /сая/	Загалмайтны шашинтны тоо / сая/	Хүн амд эзлэх хувь
1	Европ	742.550	558.260	75.2%
2	Латин Америк	590.080	531.280	90%
3	Сахарын ойр орчинь Африкийн нутаг дэвсгэр	822.720	517.340	62.9%
4	Ази номхон далайн орнууд	4.054. 990	286.950	7.1%
5	Хойд Америк	344.530	266.630	77.4%
6	Ойрхи дорнод, Хойд Африкийн бүс нутаг	341.020	12.710	3.7%
	Дэлхийн хүн ам	6.895.890	2.1573.180.000	31.5%

Дэлхийд шүтэн бишрэгчдийнхээ тоогоор 2 дугаарт ордог шашин бол Исламын шашин бөгөөд хамгийн олон ислам шашинтантай нутаг нь Ази, номхон далайн бүс нутаг юм. Ази номхон далайн бүс нутгийн нийт хүн ам ойролцоогоор 4 тэрбум бөгөөд тэнд 985.5 сая буюу бараг тэрбум буюу дөрвөн хүн тутмын нэг нь ислам шашинтан байгаа юм. Тэд одоо тус бүс нутгийн хүн амын 24.3%-ийг эзэлж байна.

Ислам шашины ирээдүйг хүн ам зүйчид болон шашин судлаачид ирэх 30-40 жилд эрс өснө гэж үзэж байна. Энэ хугацаанд Исламын шүтэн бишрэгчид бараг 75% өснө гэж тооцож байна. Тийм тохиолдолд исламчууд бараг 2.9 тэрбумд хүрэх юм. Энэ үед дэлхийн хүн ам дунджаар 35% өссөн байна гэж АНУ-ын Pew Research Center таамаглажээ<sup>5</sup>. Ингэвэл

тоо нь өөр өөр байна.

<sup>4</sup> <http://theatlantic.com>

<sup>5</sup> *The Future of World religions: Population Growth Projections, 2010-2050, Pew Research Center, Global Religious*

нь дэлхийн хүн ам 9.3 тэрбумд хүрэх юм. Тэр үед ислам шашинтнууд дэлхийн хүн амын 29.7%-тай тэнцэх болж байна. 2070 он гэхэд Ислам шашин дэлхийн хамгийн олон шүтэн бишрэгчтэй шашин болж христосын шашны олон зуун жил хадгалсан дэлхийн хамгийн том шашны байр суурийг ганхуулах төсөөлөл ч байна<sup>6</sup>.

#### ДЭЛХИЙН ИСЛАМ ШАШИНТ ХҮН АМЫН ТОО /бүс нутгаар/

	Бүс нутаг	Хүн амын тоо 2010 /сая/	Мусульман шашинтны тоо / сая/	Хүн амд эзлэх хувь
1	Ази номхон далайн орнууд	4.054. 990	985.530.000	24.3%
2	Ойрхи дорнод, Хойд Африк	341.020	317.070.000	93%
3	Сахар орчмын Африкийн нутаг дэвсгэр	822.720	248.110.000	30.2%
4	Европ	742.550	43.490.000	5.9%
5	Хойд Америк	344.530	3.480.000	1%
6	Латин Америк	590.080	840.000	0.1%
	Дэлхийн хүн ам	6.896.890	1.598.510.000	23.2%

Буддын шашинтан хүн ам 2010 оны байдлаар 487.5 саяд хүрсэн болно. Буддын шашинтнууд бараг бүгдээрээ шахуу буюу 481.3 сая нь Ази номхон далайн бүс нутагт ногддог. Үлдэх 6 сая нь дэлхийгээр тархан суудаг бөгөөд хойд америкт 3.8 сая буддист байгаа тухай судалгаа гарчээ.

#### ДЭЛХИЙН БУДДЫН ШАШИНТ ХҮН АМЫН ТОО /бүс нутгаар/

	Бүс нутаг	Хүн амын тоо 2010 /сая/	Буддын шашинтны тоо / сая/	Хүн амд эзлэх хувь
1	Ази номхон далайн бүс нутаг	4.054. 990.000	481.290.000	11.9%
2	Хойд Америк	344.530.000	3.860.000	1.1%
3	Европ	742.550.000	1.330.000	0.2%
4	Ойрхи дорнод, Хойд Африкийн бүс нутаг	341.020.000	500.000	0.1%
5	Латин Америк	590.080.000	410.000	<0.1%
6	Сахарын ойр орчинь Африкийн нутаг дэвсгэр	822.720.000	150.000	<0.1%
7	Дэлхийн хүн ам	6.895.890	487.540.000	7.1%

Нийт буддын шашинтнуудын 50% нь БНХАУ-д дангаараа ногддог. Энэ нь 2010 оны байдлаар 244.2 сая хүн болж байв. Энэтхэгээс гаралтай энэ шашныг шүтэн бишрэгчид энэтхэгийн 1.2 тэрбум хүн амын ердөө 0.8% буюу 9.2 сая нь байдаг.

Буддын шашинтны тоогоороо тэргүүлэх 10 оронд 460.6 сая буддист ногдож, үлдэх 27 сая нь дэлхийгээр тархан суурьшсан ба тэд нийт бурхан шашинтнуудын 7.1%-ийг эзэлдэг. Монголчуудын хувьд 2010 оны байдлаар 1 сая орчим хүн бурханы шашныг шүтэж байв.

Futures project. Apr.2015. pp.7-8.

<sup>6</sup> <http://theatlantic.com>, Islam could become the world's largest religion after 2070.

**БУДДЫН ШАШИНТНЫ ТООГООРОО ТЭРГҮҮЛЭХ 10 УЛС**  
**/2012 онд зарласан үр дүнд/**

	УЛС	Буддын шашинтнууд /ойролцоогоор, 2010/ сая	Хүн амд буддын шашинтнуудын эзлэх хувь	Дэлхийн буддын шашинт хүн амд эзлэх хувь
1	БНХАУ	244.230.000	18.2%	50.1%
2	Тайланд	64.420.000	93.2	13.2
3	Япон	45.820.000	36.2	9.4
4	Мянмар /бирм/	38.410.000	80.1	7.9
5	Шриланк	14.450.000	69.3	3.0
6	Вьетнам	14.380.000	16.4	2.9
7	Камбож	13.690.000	96.9	2.8
8	Өмнөд солонгос	11.050.000	22.9	2.3
9	Энэтхэг	9.250.000	0.8	1.9
10	Малайз	5.010.000	17.7	1.0
	10 орны нийлбэр	460.620.000	15.3	94.5
	Бусад буддистууд	26.920.000	0.7	5.5
	Дэлхийн буддистууд	487.540.000	7.1%	100%

Хэдийгээр хиндү шашинтны тоо тэрбум гаруй буюу дэлхийн нийт буддистуудаас 2 гаруй дахин их боловч ийнхүү бурханы шашныг тусгайлан авч үздэг нь бурханы шашны тархалт Хиндү шашиныхаас хавыгүй өргөн удам нутгийг хамардагтай холбоотой. Хиндү шашинтнуудын 90% орчим нь уугуул нутаг Энэтхэгтээ байдаг бол Буддын шашны хувьд дэлхийн бүх бүс нутагт тархсан байна. Тиймээс шашин судлалд Хиндуизмийг үндэстний шашны ангилалд оруулдаг болно.

**ДЭЛХИЙН ШАШНУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ**  
**/шүтлэгтнүүдийн тоон узүүлэлтээр/**

	Бүс нутаг	Хүн амын тоо 2010 /сая/	Бурханы шашинтны тоо /сая/	Хүн амд эзлэх хувь	Исламчуудын тоо /сая/	Хүн амд эзлэх хувь	Загалмайтаны тоо	Хүн амд эзлэх хувь
1	Ази номхон далайн бүс нутаг	4.054.990.000	481.290000	11.9%	985.530.000	24.3%	286.950.000	7.1%
2	Сахарын оир орчины Африкийн нутаг дэвсгэр	822.720.000	150.000	<0.1%	248.110.000	30.2%	517.340.000	62.9%
3	Европ	742.550.000	1.330.000	0.2%	43.490.000	5.9%	558.260.000	75.2%
4	Латин Америк	590.080.000	410.000	<0.1%	840.000	0.1%	531.280.000	90%
5	Хойд Америк	344.530.000	3.860.000	1.1%	3.480.000	1%	266.630.000	77.4%
6	Ойрхи дорнод, Хойд Африкийн бүс нутаг	341.020.000	500.000	0.1%	317.070.000	93%	12.710.000	3.7%
	Дэлхийн хүн ам	6.895.890	487.540.000	7.1%	1.598.510.000	23.2%	2.1573.180.000	31.5%

Шашин судлалд орчин үед ардын шашин шүтлэг гэдэг нэр томъёог хэрэглэх боллоо. “Ардын шашин шүтлэг”-т ихэнхдээ угсаатны нэгдлүүдийн шашин шүтлэгийг оруулдаг ба одоо байгаа Африкчуудын уламжлалт шашин шүтлэгийн хэлбэрүүд, Хятадын зарим шүтлэгүүд, Америкийн угуул иргэдийн шашин шүтлэг, Австралийн нутгийн иргэдийн шашин шүтлэг болон зарим улсуудад байдаг дээрхтэй ижил төстэй шашнуудыг бас багтааж байна. Эдгээр шашинд өртөнцийг үзэх үзлийн илэрхийлэл болсон судар ном байдаггүй онцлогтой. Ер нь ардын шашин гэдэг ойлголтыг нэг мөр тодорхойлоход хялбар биш юм.

Ардын шашин гэх тодотголтой шашин шүтлэгийн хэлбэрүүд нь бусад шашнуудыг бодвол институцлаг шинж бага бөгөөд шашин шүтлэг гэж хүлээн зөвшөөрөгддөггүй боловч нэлээд тооны шугэн бишрэгчтэй төдийгүй тухайн ард олныхоо зан заншилтай нягт холбогдсон байдаг. Үүнд, сүнслэг үзэл буюу анимизмийн үзлийг баримталдаг шүтлэгүүд, тухайлбал өвгөд дээдсийн сүнс сүлдийг шүтэх үзэлд суурилсан шүтлэгийн хэлбэрүүд, бас тэрчлэн идшид, ер бусын хүчин зүйлд шугэх, онгон шүтэх шүтлэг тухайлбал бөө мөргөлийг ардын шашинд оруулж байна.

Ардын шашин шүтлэг нь азийн орнуудын хувьд ялангуяа зонхилох болоод уламжлалт шашин шүтлэгүүдтэй нь буюу Бурханы шашин, Даогийн шашин, Күнзийн шүтлэг бишрэлтэй сүлэлдсэн байх нь элбэг гэж үзэх хандлага сүүлийн үед эрчимтэй илэрч байгаа болно. Орчин үеийн монголын шашин шүтлэгийн хэв маягийг энэ хэлбэрт хамруулж үзэх хандлага ч байна<sup>7</sup>. Ялангуяа монголчуудын язгуурын шүтлэг бөө мөргөл, уламжлалт шашин шүтлэг бурханы шашин зэрэг нь монгол хүний өдөр тутмын амьдрал дахь зан заншил, зан суртахуунтай багагүй сүлэлдсэн байдал нь монголчуудын шашин шүтлэг бол ардын шашин шүтлэг мөн гэж үзэхэд хүргэжээ<sup>8</sup>.

Ардын шашин шүтлэгтийн тоогоороо Ази номхон далайн бус нутаг тэргүүлдэг бөгөөд эхний 10 улсад Хятад, Вьетнам, Тайвань, Энэтхэг, Бразил, Өмнөд судан, Хойд Солонгос, Мянмар, Буркина Фасо<sup>9</sup> болон Нигер орж байна<sup>10</sup>.

Дэлхийн улс үндэстэн олон учир тэдний шашин шүтлэг ч олон янз. Гэвч нэг үндэстний хүрээнээс гараагүй шашнууд олон юм. Тэдгээр нь урт хугацааны түүхтэй, шугэн бишрэч ирсэн ард түмнийхээ соёл иргэншлийн сууринд нь хадгалагддаг, тэдний амьдрал, үзэл санаанд тал бүрийн нөлөөтэй Энэтхэгийн Хинду шашин (Хиндуизм), Жайны шашин (Жайнизм), Сикхийн шашин (Сикхизм), Хятадын Күнзийн шүтлэг, Даогийн шашин (Даосизм), Японы шинто шашин (Шинтоизм), Израйлчуудын Иудайн шашин (Иудаизм) зэрэг өнөө хэр хуучин өвөө хадгалан уламжлагдаар байгаа шашнууд орж байна.

Энэ шашнуудын хүн төрөлхтний соёл иргэншилд үзүүлсэн нөлөө, дэвшлийг тооцож илэрхийлэхэд хялбар бус. Тэдгээрийг дагасан амьдралын хэв маяг, бизнесийн онцлог ч бий юм. Тухайлбал, дэлхийн бэлэн хоолны томоохон сүлжээ Макдональдс энэтхэгчүүдийн шашин шүтлэг, соёл уламжлалт зохицуулан үхрийн махыг бүтээгдэхүүнийхээ орц, найрлагаас хассан байдаг. Хэрэг дээрээ Макдональдсын “үхрийн махан бургер” хамгийн алдартай нь юм. Ислам шашин шүтдэг ажилтан, албан хаагч олонгийн компаниуд ажилтан, албан хаагчдынхаа шашин шүтлэгийн эрхийг хангахын тулд исламчуудын үйлддэг өдрийн 5

<sup>7</sup> Birtalan Ágnes. *Mongolian Buddhisticised Folk religion-A Survivor throughout the Centuries, Mongolian Buddhism in Practice, 2nd International Conference on Mongolian Buddhism, April 24-25, 2017, Budapest. /Eotvos Lorand University, Faculty of Humanities/*

<sup>8</sup> Ийнхүү монголчуудын шашин шүтлэгийн хэлбэрүүд, тэдний элементүүд хоорондоо сүлэлдэн нэгдэх нь зарим талаараа монгол хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, шашин шүтлэгийн олон ургалч байдал, нөхөв талаас монгол хүний сэргээгээний онцлог, итгэл үнэмшилдээ үнэнч байх чанар, зан суртахуун зэрэгтэй нь холбоотой бөгөөд үүнд нийгмийн ахуй ч багагүй нөлөөлж байна. Нэг үзээр хэлбэл заримтууд шашынг мөнгө олох хэрэгсэл болгож байгаа нь ахуйн үндсэн хэрэгцээгээ хангахын тулд монгол хүн ямар ч шийдэл гаргахад бэлэн байгааг харуулж байна. Энд мөнгөний фетишизм буюу мөнгөөр дамжуулж бүх асуудлыг шийдэж болно гэх итгэл бишрэл үүсчээд ч давхар нөлөөлж байна.

<sup>9</sup> Баруун Африкийн Улс, 274.2 км.кв буюу багавтар нутаг дэвсгэртэй бөгөөд 2017 оны хүн амын нэгдсэн тооллогоор 20.1 сая хүн ам тоолуулсан байна.

<sup>10</sup> The Global Religious Landscape, A Report on the Size and Distribution of the World's Major Religious Groups as of 2010, Pew Research Center; The Pew Forum on Religion & Public life, Pew-Templeton:Global Religious Future Project. Washington, December 2012, p.35.

удаагийн мөргөлд нь зориулж тусгай танхим гаргасан байх нь энгийн үзэгдэл болсон байна.

Үндэстний шашин гэж зөвхөн аль нэг улс үндэстэн шүтдэг эсвэл тухайн улсын гадна байгаа тухайн үндэстнүүд шүтдэг шашин шүтлэгийн хэлбэрийг хэлнэ. Нэг улс, үндэстэн дангаараа шахуу шүтдэг буюу үндэстний шашиннуудыг “бусад шашин шүтлэг” гэж судалгаанд ангилж авч үзэх нь элбэг байна. Үндэстний шашинтууд дэлхийн хүн амын ойролцоогоор 1% буюу 60 шахам сая хүн шүтэж байна. Олон улсуудын хүн амын тоологоос үзвэл Бахайн шашин, Даогийн шашин, Жайны шашин, Шинто шашин, Сикхийн шашин, Тэнрикё, Викка, Зороастрын шашин (Zoroastrianism) зэрэг шашин шүтлэгийн хэлбэрийг бусад шашин ангилалд нэгтгэн оруулж байна. Харин хиндү шашиныг энд оруулсангүй.

Үндэстний шашин шүтлэг ази номхон далайн бүс нутагт хамгийн их тархсан бөгөөд 51.8 сая буюу нийт үндэстний шашин шүтлэгтнүүдийн 89.2% нь энэ бүс нутагт оршин сууж байна. Тэд бусад бүсүүдийн хувьд тухайлбал: Хойт Америкт 2.2 сая буюу 4% нь, Сахар орчмын Африкийн нутаг дэвсгэрт 1.9 сая буюу 3% нь, Латин Америк болон карибын тэнгисийн бүсэд 0.99 сая буюу 2% нь, Европт 0.93 сая буюу мөн 2% орчим нь, Ойрх дорнод болон Хойт Африкт 230 000 буюу 1 орчим хувь шүтэн бишрэгч тус тус ногдож байгаа тухай судалгаа бий юм.

Иудайн шашин шүтлэгтэн дэлхийн хүн амын 0.2%-ийг эзэлдэг ба одоо бараг 14 сая гэж үзэж байна тэдний тоо нь тус шашин дахь иудайн шашинтуыг тодорхойлдог үзэл баримтлалтай нь холбоотой юм. Тухайлбал, тус шашинд иудайн шашин шүтлэгтэй эмээ, өвөөтэй хэн ч жүүд хүнд тооцогддог болон эхийн талыг барьж шашин шүтлэгтний тоогоо тодорхойлдог нь ийнхүү иудайн шашин шүтлэгтэн өндөр хувьтай байна гэж үзэх хандлага бий. Энэ шашны шүтлэгтнүүд Израйль улсын иргэд болон АНУ дахь жүүдүүдээс бүрддэг онцлогтой.

Хиндү шашинтууд дэлхийн хүн амын 15%-ийг эзэлж байгаа нь дэлхийн шашин болох Бурханы шашинтуудын тооноос даруй 2 дахин их байна. Энэ нь тус шашиныг бусад шашин гэх ангилалд оруулах үндэслэл болж байна. Хэдийгээр тэрбум хүн энэ шашныг шүтэж байгаа ч энэтхэгийн нутаг дэвсгэрт хашигдаж байгаа нь үндэстний буюу төр улсын шашин болохыг нотолж байна.

Үндэстний шашин шүтлэгтнүүдийн тоогоороо дэлхийд тэргүүлэх 10 орныг дараахь байдалтай тодорхойлж байна. Үүнд:

Дугаар	Улс	2010 оны тоологын дүн /сая/	Дэлхийн хүн амд Эзлэх хувь	Орны сүсэгтнүүдэд эзлэх хувь
	Энэтхэг	27,56	2.3%	47.4%
	Хятад	9,0	0.7	15.6
	Япон	5,89	4.7	10.1
	Тайвань	3,76	16.2	6.5
	Хойд Солонгос	3,13	12.9	5.4
	АНУ	1,9	0.6	3.3
	Камерун	0.53	2.7	0.9
	Кени	0.5	1.2	0.9
	ИБНВУ	0.5	0.8	0.9
	Сингапур	0.49	9.7	0.9
	<b>10 орны дүн</b>	<b>53.35</b>	<b>1.7</b>	<b>91.8</b>
	Бусад үлдэх орнууд	4.76	0.1	8.2
	<b>Бүгд</b>	<b>58,11</b>	<b>0.8</b>	<b>100</b>

Дэлхийн шашны тархацын ирээдүйн төвшинг таамагласан судалгаанаас үзвэл 2070 он гэхэд Христосын шашинтан болон Исламын шашинтууд эзлэх хувиараа тэнцэж аль

аль нь дэлхийн хүн амын 32.3%-д хүрнэ гэж таамаглаж байна<sup>11</sup>. 2100 он гэхэд Исламын шашин дэлхийн хамгийн том шашин болж дэлхийн нийт хүн амын 34.9%-д хүрэх ба тэр үед христосын шашинтнууд 33.8% буюу бараг өнөөгийн төвшиндөө хэвээрээ байна гэжээ.

Ингэж ислам шашинтнууд олшрох шалтгаан нь тэд насны хувьд залуу бөгөөд нөхөн үржихүй сайн байгаагаар тайлбарлаж байна. Харин бурханы шашинтнууд үл ялиг буурах магадлал байгааг хөгшрөлтгэй холбож байгаа юм.

Дэлхийн шашин шүтлэгтнүүдийн тундаж нас 28, нийт шашин шүтлэгтнүүдийн дундаж нас 31 байхад буддын шашинтнуудын дундаж нас 34 байна. Ийнхүү дундаж нас өндөр байгаа нь буддистуудын тоо ирээдүйд буурах шалтгаан нь болохоор байна. Түүнээс гадна буддын шашныг шүтгэн бишрэгчид харьцангуй өндөр настай хүмүүс байна.

Шашин шүтлэгтнүүдийн дундаж нас дараахь байдалтай байна:

Шашнууд	Ислам	Хинду	Христ	Бусад	Үндэстний шашин	Шашингүй үзэлтнүүд	Буддын Шашинтнууд	Иудайн Шашинтнууд
Дундаж Нас	23	26	30	32	33	34	34	36

Хамгийн өндөр дундаж нас Иудайн шашинд ногдож байна. Тэд “дэлхийн шашнууд”-ын /Христосын, Исламын, Буддын/ дундаж наснаас 8, дэлхийн нийт шашин шүтлэгтнүүдийн дундаж наснаас 5 насаар ах байна.

Шашнуудын ирээдүйн төлөв байдлыг хүснэгтээр илэрхийлбэл дараахь байдалтай байна. Үүнд:

#### ДЭЛХИЙН ШАШИН ШҮТЛЭГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ /2050 он хүргэл/

	Шашин	2010 он /тэрбум/	2050 он /тэрбум/	Дэлхийн хүн амтай харьцуулбал осолт/бууралт	
Загалмайтны шашин		2.17	2.92	0.75	35%
		31.4%	31.5%	0.1	
Ислам шашин		1.6	2.76		73%
		23.2%	29.7%		
Шашингүй үзэл		1.13	1.23	0.1	
		16.4%	13.2%		
Хинду шашин		1.03	1.38	0.35	
		15%	14.9%	0.1	
Бурханы шашин		0.49	0.49		-0.3%
		7.1%	5.2%		
Үндэстний шашин		0.40	0.45	0.05	
		5.9%	4.8%	1.1%	
Бусад		0.06	0.06		
		0.8%	0.7%		
Иудайн шашин		0.01	0.02	0.01	
		0.2%	0.2%		
Дэлхийн хүн ам	6.89	35%	9.31		

<sup>11</sup> Мөн тэнд, p.14.

Хиндүизм болон Иудаизм ирэх 2050 он гэхэд өнөөгийнхөө төвшинг хадгална гэж үзэж байна.

Харин дэлхийн шашингүйчүүдийн тоо АНУ, Франц зэрэг олон улсуудад өсөх төлөвтэй байгаа. Шашингүйчүүд нэмэгдэх хандлага монголчуудын дунд ч ажиглагдаж байна. МУИС-ийн 2013 онд хийсэн судалгаагаар 41.3% нь<sup>12</sup> шашин шүтдэггүй гэж хариулсан нь бий. 2010 оны байдлаар монголчуудын 39 хувь нь шашингүй үзэлтэн байсан бол 3 жилийн дотор бараг 2% өссөн байдалтай байна. 2010 оны судалгаа бол нийт хүн амд эзлэх хувь, 2013 оны судалгаа нь зөвхөн төвийн бүс, хот суурин газрын иргэдээс түүвэрлэн авсан судалгааны үр дүн болно.

Үндэстнүүд, ард түмнүүд ийнхүү шашин шүтлэгээрээ ялгаатай байгаа нь тэд ертөнцийг үзэх үзэл, соёл, амьдралд хандах хандлага, үнэлэмж болон өдөр тутмын амьдралын хэв маяг, зан заншлаараа ялгаатай байхад нөлөөлдөг. Шашин, шашны үзэл онол, итгэл үнэмшил, зан заншлын ялгаа нь хүмүүст ийнхүү ялгаатай орчныг бий болгож байна.

Гэсэн хэдий ч шашин нь хүнийг нийгмийн ахуйн илрэх хэлбэрт нь, соёлд нь ялгаа тогтоож болох ч хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн баялгаас хүртэх хувь хэмжээ, тэдний эрх чөлөөнд огт хамаагүй юм. Үүнийг дэлхий дахинд Хүний эрхийн тунхагаар (1948) болон улс бүр өөрийнхөө хууль эрх зүйн зохицуулалтаараа баталгаажуулдаг юм. Хүмүүс ялгаатай байх нь тэднийг ялгаварлах үндэслэл болох ёсгүй.

<sup>12</sup> МУИС-ийн шашин судлалын тэнхимд хийгдсэн төвийн бусийн 3045 хүнээс авсан түүвэр судалгаа. 2013.

## ABSTRACT

In recent decades (in 2010), many countries have carried out nationwide population and religion census. Numerous surveys of religion and religious trends and its reach have revealed that roughly 83.7% (5.8 billion) of world's population were identified having religious beliefs, of which 31.5% (2.1 billion) Christians, 23.2% (1.6 billion) Muslims, 7.1% (487.5 million) Buddhists, 15% (1.31 billion) Hindus, 5.9% adherents of folk religion, 0.2% Jews and the remaining 0.8% were identified following other religions. The surveys have also revealed that only 16.3% (1.1 billion) of world's population were estimated to have no religious affiliations.

Researchers divide world broadly into 6 different regions- Asia-Pacific, Sub-Saharan Africa, Europe, Latin America, North America and Middle East and North African region- these regions are diverse in many respects- religion and its reach, religious faith and value, cultural heritage, tradition, and the number of population.

## НОМ ЗҮЙ

1. The Global Religious Landscape, A Report on the Size and Distribution of the World's Major Religious Groups as of 2010, Pew Research Center, The Pew Forum on
2. Religion&Public life, Pew-Templeton:Global Religious Future Project. Washington, December 2012.
3. The Future of World religions: Population Growth Projections, 2010-2050, Pew Research Center, Global Religious Futures project. Apr.2015.
4. Birtalan Egnés. Mongolian Buddhist Folk Religion-A Survivor throughout the Centuries, Mongolian Buddhism in Practice, 2nd International Conference on Mongolian Buddhism, April 24-25, 2017, Budapest. /Eotvos Lorand University, Faculty of Humanities/
5. МУИС-ийн шашин судлалын тэнхимд хийгдсэн төвийн бүсийн 3045 хүнээс авсан түүвэр судалгаа.2013.
6. <http://theatlantic.com> http://theatlantic.com, Islam could become the world's largest religion after 2070.